

# Төгс эзэмших сургаал: 1-р үнэлгээний шалгалт—Суралцах зааварчилгаа

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

## Судрын эшлэл, түлхүүр үг хэллэгийг цээжлэх

Төгс эзэмших сургаалын судрын хэсэг, түлхүүр үг хэллэгийг сайн мэддэг бол. Та давтлагадаа Doctrinal Mastery гар утасны аппликэйшнийг татаж аваад, ашиглаж болох юм.

Матай 5:14–16. “Та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг.”

Матай 11:28–30. “Зүдэж зүтгэгсэд хийгээд хүнд ачаа үүрсэн бүгд ээ, Над дээр ир. Би та нарыг амраая.”

Матай 16:15–19. Есүс “Би чамд тэнгэрийн хаанчлалын түлхүүрийг өгнө” хэмээн хэлэв.

Матай 22:36–39. “Чи Бурхан Эзэнээ ... хайрла. Чи хөршөө ... хайрла.”

Лук 2:10–12. “Өнөөдөр, Давидын хотод Аврагч, Эзэн Христ та нарын төлөө мэндэллээ.”

Лук 22:19–20. “Намайг дурсаж” ариун ёслолоос хүрт хэмээн Есүс Христ зарлигласан.

Лук 24:36–39. “Учир нь сүнсэнд та нарын харж байгаа Над шиг яс, мах байдаггүй юм.”

Иохан 3:5. “Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр Бурханы хаанчлалд орж үл чадна.”

Иохан 3:16 “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласандаа цорын ганц Хүүгээ өгсөн.”

Иохан 7:17. “Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсвэл тэрээр энэ сургаалыг мэднэ.”

Иохан 17:3. “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн.”

## Сургаалыг бодит амьдрал дээрх нөхцөл байдалд хэрэгжүүлэх

- Сүмд заасан сургаал нь Бурханаас ирсэн гэсэн хувийн гэрчлэл олж авах талаар Шинэ Гэрээнд юу гэж заадаг вэ? гэж асуусан хүнд хариулахын тулд төгс эзэмших сургаалын нэг эсвэл хэд хэдэн судрын хэсгийг ашигла.
- Хэрэв та Бурханы тэднийг гэх хайрын тухай хэн нэгэнд заах бол Шинэ Гэрээний төгс эзэмших сургаалын судрын аль аль хэсгийг ашиглаж болох вэ? Та Бурханы хайрын тухай тайлбарлахдаа эдгээр судрын хэсгийг хэрхэн ашиглаж болох вэ?

Төгс эзэмших сургаалын судрын аль аль хэсэг танд хамгийн их нөлөөлсөн талаар хуваалцахад бэлд. Тухайн хэсэг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын талаар танд юу заадаг вэ?

## Сүнслэг мэдлэг олж авах зарчмууд

2022 оны *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материалын* “Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсгийн 5–12-р догол мөрийг эргэн харна уу.